

## ЗӨВЛӨМЖ

**ХАСХОМ ГАРГАХ НИЙТ АЛБАН ХААГЧИД 2-Р САРЫН 01-НИЙ ДОТОР МЭДҮҮЛГЭЭ ГАРГАЖ, ХЯНУУЛАН / ХАСХОМ бөглөөд ЭБАТ-даа шууд мэдэгдэнэ үү./ БАТАЛГААНЫ ХУУДСАА ABLE -ийн чаатаар, мөн биечлэн, эсхүл [mongoljingo@mcud.gov.mn](mailto:mongoljingo@mcud.gov.mn) хаягаар гэх мэт аль боломжит хэлбэрээр ирүүлэхийг мэдэгдэж байна.**

ХАСХОМ-ыг шинэчлэн гаргах гэж байгаатай холбогдуулан дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Нийт албан хаагчид ХАСХОМ гаргахдаа анхаарна уу.

1. Энэ жилээс <https://meduuleg.iaac.mn> цахим системд мэдүүлэг гаргах үндэслэл, тайлант он, орлого, албан тушаалын нэр, албан тушаалын ангилал зэрэглэл, албан тушаалд томилогдсон огноо гэх мэт мэдээлэл дутуу буюу мэдүүлээгүй эсхүл буруу сонгосон тохиолдолд тухайн мэдүүлэг гаргагчаас болон ЭБАТ-аас баталгаажилт хийгдэхгүй буюу дээрх хураангуй мэдээг цахимаас хөрвүүлэхэд харагдахгүй болохыг анхаарна уу.

2. ХАСХОМ мэдүүлэх систем 2-р сарын 15-нд хаагдах хэдий ч АТГ-аас цаг үеийн нөхцөл байдал хүнд, хөл хориотой байгаагаас зарим байгууллагууд ажиллахгүй банк санхүүгийн байгууллагаар үйлчлүүлэхэд дараалал ихтэй байгаа тул санхүүгийн холбоотой баримт цуглуулахад албан хаагчид багагүй цаг зарцуулахаар байгаа, түүнчлэн Цагаан сарын баяр эрт буюу 2-р сарын 12-нд болох тул ХАСХОМ-ыг аль болох эрт өгөхийг анхааруулсан.

3. Зарим албан хаагч нар огт ашиглахгүй байгаа мэйл хаягаа ХАСХОМ-д бүртгүүлсэн байдаг тул цаг нь тулсан үед хугацаа их алддаг. Иймд даруй ЭБАТ-даа хэлж тогтмол ашигладаг, аль ч газраас нэвтрэх боломжтой, нууц үгээ мэдэж байгаа цахим хаягаа өгч системд өөрчлөлт оруулах нь зүйтэй.

4. ХАСХОМ мэдүүлэхдээ дараахь нийтлэг зөрчлийг гаргасаар байгааг АТГ-аас анхааруулсан.

Үүнд:

-Хамаарал бүхий этгээдээ мэдүүлэхгүй байх;

-Гэр бүлийн гишүүн гэж хэнийг хэлэхийг ойлгоогүй эсхүл буруу ойлгосноос болж хамт амьдардаггүй аав, ээж, ах, эгч, дүүгээ бичдэг. Гэр бүлийн гишүүн гэсэн хэсэгт **Хамт амьдарч байгаа болон өрхийн бүртгэлд бүртгэлтэй эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд, эцэг, эхийг бичнэ.** Мэдүүлгийг бөглөхдөө доорх тайлбар, зааврыг анхааралтай уншиж байх;

-Ам бүлээс тусдаа гарсан хүүхдээ цуг бичих тохиолдол байна. Гэхдээ өрхийн бүртгэлд байгаа бөгөөд гадаадад байгаа хүүхдийнхээ орлогыг мэдүүлнэ.

-Их хэмжээний өөрчлөлтийн талаар зөв ойлголт хэрэгтэй байна. Энэ ойлголт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс шалтгаалан өөрчлөгдөж байдаг. 2020 онд ХХДХ

420000 төгрөг байсан тул 1 сарын ХХДХ-г 250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэнэ гэхээр 105 саяаас давсан бол их хэмжээний өөрчлөлт болох нь.

-Хадгаламжийн хүүгийн орлогоо мартаж байна;

-Компаний ноогдол ашигаа тусгахгүй байна;

-Үл хөдлөх хөрөнгө борлуулсан орлого бичихгүй байна. Гэрчилгээ гараагүй байгаа гэдгээр бичихгүй байгаа нь буруу. Гэтэл албан ёсоор бүртгүүлээгүй боловч мөнгөн орлогоороо холбогдсон байдаг. Тэдэн төгрөг шилжүүлсэн, гэрчилгээ тэдийд гарна гэх мэтээр тайлбар хэсэгт сайн бичих;

-Орон сууцны доорх дулаан гаражаа бичихгүй байна.;

-Орлого дээр мөнгөний орон алдаж бичих тохиолдол маш нийтлэг байгааг онцгой анхаар;

-ХАСХОМ-ыг мэдүүлэг гаргагч өөрөө баталгаажуулсан бол ЭБАТ баталгааг цуцлаж болно, харин мэдүүлэг гаргагч, ЭБАТ 2-уулаа баталгаажуулсан бол АТГ-д хандаж цуцлуулна. Өмнөх жилүүдэд АТГ-рүү ЭБАТ утсаар яриад зохицуулаад цуцлуулж болдог байсан бол энэ жилээс ЭБАТ утсаар ярьсан ч баталгаа цуцлахгүй болсон. Заавал АТГ-т албан бичгээр хандаж гаргасан алдаагаа тоочиж ямар учраас засуулах болсоноо бичиж, шаардлагатай баримтыг хавсаргаж байж засуулах болсон. Иймд алдаагүй хийхэд анхаарч маш хариуцлагатай бөглөөрэй.

-ХАСХОМ-ыг тухайн албан тушаалд шинээр /түр болон байнга/ томилогдсон эсхүл сонгогдсон бол, мөн хөрөнгө орлогод нь их хэмжээний өөрчлөлт орсон бол 30 хоногийн дотор гаргах ёстой. Мөн тухайн жилийн хөрөнгө орлогын мэдүүлгийг дараа оны 2-р сарын 15-ны дотор гаргадаг. Энэ 3 тохиолдлыг хооронд нь хольж хутгаад байна. /Системийг 2-р сарын 15-ны өдрөөр тасалбар болгон хааж, мөн өдрөөс эхлэн шууд хяналт шалгалтын ажил АТГ дээр эхэлдэг./

Мөн бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор олон албан хаагчийн ХАСУМ /урьдчилсан мэдүүлэг/-ыг цаасан болон цахим хэлбэрээр авч АТГ-т хянуулахаар хүргүүлсэн. Гэтэл зарим албан хаагчид дахин дахин ХАСХОМ авлаа гэх ойлголт хандлагатай байна. Иймд хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд захирагдан дээрх үндэслэл, шалтгаанаар мэдүүлгийг авч байгааг ойлгох нь зүйтэй.

-Гэр бүлийн болон төрөл садангийн хүнээс бусад этгээдээс авсан нэг удаагийн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс нь тухайн албан тушаалтны 1 сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн, эсхүл нэг эх сурвалжаас нэг жилийн туршид хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ хөлс тухайн албан тушаалтны 3 сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн бол уг албан тушаалтан энэ тухай ЭБАТ-даа 30 хоногийн дотор бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

5.ХАСУМ /Хувийн ашиг сонирхлыг урьдчилсан мэдүүлэг/-ийг тухайн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн этгээдээс гаргуулан авч АТГ-т хүргүүлснээр ажлын 10 өдөрт багтаан хянаж албан бичгээр хариуг хүргүүлдэг.

6.Оны зааг дээр томилогдсон хүмүүс 30 хоногтоо багтаж байвал шинээр болон шинэчлэн гаргасан гэсэн цонхыг давхар зөвлөөд мэдүүлгийг гаргана. Хэрэв 30 хоног нь хэтрэхээр байвал 2019, 2020 оныхыг давхар авна. Гэхдээ манайд ийм хүн байхгүй байгаа.

7.Манай байгууллага дээр Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасны дагуу захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, тэдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах үүргээ хангалттай биелүүлэхгүй байгааг цаашид анхаарна уу. Өнгөрсөн хугацаанд Худалдан авах ажиллагаатай холбоотойгоор 192 мэдэгдэл хүлээж авсан бөгөөд тухай бүрт нь Шилэн дансны мэдээлэлд оруулж ажилласан.

ЖИЧ: Дээрх зөрчлүүд ХАСХОМ гаргадаг албан хаагчдын дунд нийтлэг гарч байгаа талаар АТГ-аас мэдээлсэн бөгөөд манай дээр харьцангуй бага байдаг. Гарсан зөрчлийг цаг тухайд нь арилгаад, засуулаад явдаг. Гэсэн ч анхаарал илүүдэхгүй байх. 10 гаран жил гаргасан учраас одоо бараг сурчихсан байх гэж найдаж байна. БҮГДЭД НЬ АМЖИЛТ ХҮСЬЕ.

Зөвлөмж бичсэн: БХБЯ-ны ЭБАТ Д.Монголжингоо

2021.12.14